

ХАМГААЛАЛТТАЙ АЖ АХУЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ХЯНАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг бүртгэх, баталгаажуулах, хянах, бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт нэгдэн орсон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3.Нэр, томъёоны тодорхойлолт

1.3.1.“мал, амьтны дэд сүрэг” гэж хамгаалалттай аж ахуйн байгууламж дахь онилсон өвчинд мэдрэмтгий мал, амьтныг; [бусад мал, амьтнаас тусгаарлан хамгаалалттай аж ахуйд маллаж байгаа эрүүл мал, амьтныг]

1.3.2.“онилсон өвчин” гэж олон улсын худалдааны хорио цээрт мал, амьтны халдварт өвчний жагсаалтаас сонгосон нэг болон хэд хэдэн өвчнийг;

1.3.3.“биохамгааллын заавар” гэж хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн нэгж бүр биохамгааллын шаардлагыг хэрэгжүүлэх зааварчилгааны баримт бичгийг; [гэж хамгаалалттай аж ахуйн шаардлагуудыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ болон тухайн аж ахуйд дагаж мөрдөх биохамгааллын стандарт ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг]

1.3.4.“идэвхтэй тандалт” гэж мал, амьтны дэд сүрэгт онилсон өвчний халдварыг илрүүлэхэд чиглэсэн зорилтот үйл ажиллагааг;

1.3.5.“гаднах тандалт” гэж хамгаалалттай аж ахуйн тусгаарлагдсан бүсээс гадна тодорхой орон зайд онилсон өвчний эрсдийг тодорхойлох зорилтот үйл ажиллагааг;

1.3.6.“оролцогч аж ахуйн нэгж” гэж хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт оролцогч хуулийн этгээдийг; [хэрэв хэд хэдэн хуулийн этгээд хамтран нэгдсэн биохамгааллын заавар дагаж мөрдөх тохиолдолд оролцогч аж ахуйн нэгж гэж байна]

1.3.7.“үйлдвэрлэлийн байгууламж” гэж мал тэжээх бордох, төхөөрөх, мах боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрлэлийн нэгжийг;

1.3.8.“орц” гэж хамгаалалттай аж ахуйн байгууламжид оруулах амьд мал, малын үр хөврөл, тоног төхөөрөмж, малын тэжээл, ус, эм бэлдмэл зэргийг;

1.3.9.“гарц” гэж хамгаалалттай аж ахуйгаас гаргах үед эрсдэлийн менежмент шаардагдах мал амьтан, генетикийн бүтээгдэхүүн, малын гаралтай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, хог хаягдал зэргийг;

1.3.10.“нийлүүлэлтийн сүлжээ” гэж хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлж байгаа үйл ажиллагааг; [түүхий эд нийлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдаалах зэрэг хоорондоо холбогдсон үйл ажиллагааны холбоос]

1.3.11.“хөндлөнгийн хяналт” гэж төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагааг;

1.3.12.“дотоод хяналт” гэж хамгаалалттай аж ахуйн захиргаанаас биохамгааллын зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буйг тодорхойлох үйл явцыг; [журмын төслийн холбогдох хэсэгт оруулах “ТХШТХ-ийн 6.4-т заасны дагуу хамгаалалттай аж ахуй нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа хяналтыг]

1.3.13.“итгэмжлэгдсэн баталгаа” хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт оролцогч бүр өөрийн нийлүүлж буй мал амьтан, генетикийн материал, мах, махан бүтээгдэхүүн нь биохамгааллын шаардлага хангасан болохыг нотолсон баримт бичгийг; [мал эмнэлгийн гэрчилгээний системтэй холбох талаар ажлын хэсэг дотроо шийдэх]

1.3.14.“үл тохирол” гэж хамгаалалттай аж ахуйн биохамгааллын зааврыг хэрэгжүүлээгүй нөхцөл байдал;

1.3.15.“залруулах арга хэмжээ” гэж хамгаалалттай аж ахуйн нэгжээс үл тохирлыг засаж залруулахаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг;

1.3.16.“албан ёсны баталгаажуулалт” гэж Монгол Улсаас мал, малын гаралтай бүтээгдэхүүн экспортлоход мал, амьтны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын эрсдлийг удирдах үндэсний тогтолцоог.

Хоёр.Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт оролцсон аж ахуй нэгжүүдэдгийн үйл ажиллагаанд тавих нийтлэг болон тусгай шаардлагууд

2.1.Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт оролцсон хамгаалалттай аж ахуйн нэгж нь малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын шаардлагыг тусгахын зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэр, биохамгааллын удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, мал, амьтан нь зорилтот өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулах шаардлагуудыг хангана.

2.2.Хамгаалалттай аж ахуй нь удирдлага, зохион байгуулалтын дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь биохамгааллын зааврын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий удирдах албан тушаалтныг томилох;

2.2.2.хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах зүйлийг тодорхойлсон стратеги төлөвлөгөөтэй байх:

2.2.2.1.экспортын зорилтот зах зээл;

2.2.2.2.мал, амьтны төрөл;

2.2.2.3.онилсон өвчин;

2.2.2.4.хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламж;

2.2.2.5.оношлогооны эрх бүхий лаборатори;

2.2.2.6.хөндлөнгийн хянан магадлагч;

2.2.2.7.биохамгааллын заавраа боловсруулах, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох;

2.2.2.8.малын эрүүл мэндийн оношлогооны лаборатори болон хөндлөнгийн хянан баталгаажуулалт [ISO17020, ISO9001 стандартаар итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн хуулийн этгээд байх] хийх байгууллагатай гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх;

2.2.2.9.хамгаалалттай аж ахуйн мал, малын гаралтай бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн баталгаа олгох;

2.2.2.10.туршилтын хугацааны биохамгааллын зааврын хэрэгжилтийн тайлангаа хугацаанд нь илгээх;

2.2.2.11.үл тохирлыг тухай бүрд нь залруулах арга хэмжээ авах замаар шийдвэрлэх.

2.3.Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч дараах нийтлэг шаардлагыг хэрэгжүүлнэ:

2.3.1.хамгаалалттай аж ахуй бүр биохамгааллын заавраа боловсруулсан байх;

2.3.2.хамгаалалттай аж ахуй нэг ба түүнээс дээш төрлийн мал, амьтныг тусгаарлаж байгаа тохиолдолд малын төрөл, өвчин тус бүрээр биохамгааллын заавраа боловсруулсан байх;

2.3.4.хамгаалалттай аж ахуйг бүрдүүлэгч үйлдвэрлэлийн байгууламж бүрийг тодорхойлох;

2.3.5.хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламж бүр өөрийн үйл ажиллагаанд мөрдөх биохамгааллын зааврыг боловсруулах;

2.3.6.итгэмжлэгдсэн баталгаа гаргах мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний оролцогч бүрийг биохамгааллын зааварт нарийвчлан тодорхойлох;

2.3.7.хамгаалалттай аж ахуйн үйлдвэрийн мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх мал эмнэлгийн албатай байх.

2.4.Малын эрүүл мэндийг хамгаалах, өвчний халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд дараах тусгай шаардлагыг хэрэгжүүлнэ.

- 2.4.1. үйлдвэрлэлд эрсдэл учруулж болзошгүй орцыг хянах;
- 2.4.2. ажилчид, зочид, тээврийн хэрэгсэлтэй холбоотой биохамгааллын эрсдэлийн удирдлагыг зохион байгуулах, үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд дотоод хяналт, мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх;
- 2.4.3. малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- 2.4.4. хамгаалалттай аж ахуйгаас гарах бараа бүтээгдэхүүнд гарцын хяналтыг хэрэгжүүлэх, мөшгөн тогтоох бүртгэл хөглөх;
- 2.4.5. дотоод хяналтын зааварчилгааны дагуу хяналтыг хэрэгжүүлж баримтжуулах;
- 2.4.6. хөндлөнгийн эрх бүхий этгээдээр аудит хийлгэж хянан баталгаажуулах.

2.5. Малын эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах тусгай шаардлагыг хэрэгжүүлнэ.

2.5.1. тухайн үйлдвэрлэлийн үе шатанд онилсон өвчин үүсгэх эрсдэлтэй, гаралтыг илтгэж болох эгзэгтэй цэгүүдийг тогтоож, гүйцэтгэлийн хяналт тавих;

2.5.2. үхэл хорогдол, өвчлөлийн тохиолдол бүрийг шинжилж, онилсон өвчний гаралт байгаа эсэхийг тогтоох;

2.5.3. онилсон өвчин бүрээр эрүүл болохыг нотлох идэвхтэй тандалт хийх;

2.5.4. хамгаалалттай аж ахуй орчмоос халдвар орж ирэх эрсдэлийг тогтоох, эрсдлийг удирдах зорилгоор онилсон өвчний гадна тандалт хийх.

2.5.5. онилсон өвчин бүрийг оношлоход ДМАЭМБ-ын баталсан шинжилгээний аргыг хэрэглэнэ.

2.5.6. шинжилгээ хийх оношилгооны лаборатори нь ISO:17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байх ба итгэмжлэлийн хүрээнд онилсон өвчнийг оношлох шинжилгээний арга багтсан байна.

2.5.7. үндэсний хууль тогтоомж болон стратегид нийцүүлэн онилсон өвчин бүрээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, дархлаажуулалтын үр дүнг тодорхойлох идэвхтэй тандалтыг хийнэ.

2.5.8. Мал, амьтанд хэрэглэх эмэнд дор дурдсан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2.5.8.1. малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн малын төрөлд хэрэглэхийг зөвшөөрсөн;

2.5.8.2. үйлдвэрлэлийн сайн дадал нэвтрүүлсэн үйлдвэрийн бүтээгдэхүүн;

2.5.8.3. үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэсэн;

2.5.8.4. малын эмчийн хяналт, зааварчилгааны дагуу өгсөн;

2.5.8.5. үйлдвэрлэгчээс тогтоосон биеэс гадагшлах хугацаанаас өмнө төхөөрөх, хугацаа нь тодорхойгүй тохиолдолд төхөөрөхөөс өмнө 63 хоногийн дотор мал, амьтанд хэрэглэхгүй байх.

2.6. Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт хамрагдсан оролцогч аж ахуйн нэгжийн үйлдвэр нь дор дурдсан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2.6.1. хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт хамрагдсан оролцогч аж ахуйн нэгжийн үйлдвэр нь үндэсний болон олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг мөрдөх;

2.6.2. САНР/НАССР/ISO 22000 стандартаар магадлан итгэмжлэгдсэн байх;

2.6.3. микробиологийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, баримтжуулсан байх;

2.6.4. малын эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, баримтжуулсан байх.

Гурав. Хамгаалалттай аж ахуйг бүртгэх

3.1. Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрт хамрагдах өргөдөл гаргах, бүртгэл хөглөх үйл ажиллагааг дараах байдлаар зохицуулна.

3.2. Энэ журмын 2 дугаар бүлэгт заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан гэж үзвэл стратеги төлөвлөгөө, биохамгааллын заавар, үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсарган хамгаалалттай аж ахуйгаар бүртгүүлэх хүсэлтээ Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.3. Ирүүлсэн хүсэлтийг ажлын 20 өдрийн дотор хянаад биет хяналт шалгалт явуулж дараах шаардлагыг хангасан бол хамгаалалттай аж ахуйгаар түр бүртгэнэ.

3.3.1. хамгаалалттай аж ахуйн биохамгааллын заавар, үйл ажиллагааны төлөвлөгөө [ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт, хэрэгжүүлэх цогц арга хэмжээний удирдамж] нь энэ журам болон биохамгааллын нийтлэг зааварт нийцэж байгаа эсэх;

3.3.2.мал эмнэлгийн лаборатори болон хөндлөнгийн хянан баталгаажуулалт хийх итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсан эсэх;

3.3.3.онилсон өвчнөөс ангид гэдгийг нотлох зорилготой эхний ээлжийн идэвхтэй тандалтын үр дүн сөрөг гарсан.

3.4.Энэ журмын 3.5, 3.6-д заасан маягтын дагуу Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамгаалалттай аж ахуйг албан ёсоор түр бүртгэлд оруулж дараах мэдээллийг нээлттэй болгоно:

3.4.1.хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр, хаяг;

3.4.2.хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламж бүрийн нэр, хаяг, газар зүйн байршил;

3.4.3.хамгаалалттай аж ахуйд онилсон өвчний шинжилгээ хийх мал эмнэлгийн лаборатори;

3.4.4.хамгаалалттай аж ахуйд хөндлөнгийн хянан баталгаажуулалт хийх итгэмжлэгдсэн байгууллага.

3.5.Батлагдсан Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн бүртгэлд дараах маягтыг ашиглана.

Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн нэр	Онилсон өвчин	Удирдлага, зохион байгуулалтын алба	Баталсан огноо	Биохамгааллын удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөөний загварыг байршуулсан вэб сайтын холбоос

3.6.Батлагдсан Хамгаалалттай аж ахуйн бүртгэлд дараах маягтыг ашиглана.

Хамгаалалттай аж ахуйн нэр	Хамгаалалттай аж ахуйн хөтөлбөрийн нэр	Оролцогч аж ахуйн нэгж(үүд)	Зөвшөөрлийн статус	Батлагдсан огноо	Зөвшөөрөлтэй үйлдвэрийн тоо	Батлагдсан оношлогоо үзүүлэх байгууллага	Батлагдсан аудитор

3.7.Түр бүртгэлд хамрагдсан хамгаалалттай аж ахуй дараах шаардлагыг хангасан бол байнгын бүртгэлд хамруулна/бүртгэнэ/оруулна:

3.7.1.биохамгааллын зааврын хэрэгжилтийг улирал бүр хангалттай гэж дүгнэсэн;

3.7.2.хөндлөнгийн хяналтын аудитаар үйлдвэрт ноцтой болон том үл тохирол илрээгүй;

3.7.3.онилсон өвчнөөс ангид гэдгийг нотлох зорилготой хоёр дахь ээлжийн идэвхтэй тандалтын үр дүн сөрөг гарсан;

3.7.4.түр бүртгэлд хамрагдсан хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч Мал эмнэлгийн ерөнхий газарт тайлангаа тогтмол ирүүлэх.

Дөрөв.Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа

4.1.Хамгаалалттай аж ахуйн мал эмнэлгийн алба дор дурдсан малын эрүүл мэндийн үйл ажиллагааг заавал хэрэгжүүлнэ:

4.1.1.мал, амьтны үхэл, хорогдол бүрийн шалтгааныг шинжилж тогтоох;

4.1.2.онилсон өвчний сэжиг бүхий тохиолдол бүрийг шинжилж тогтоох;

4.1.3. малын эмч нь үхэл хорогдол, өвчлөлийн тохиолдол бүрийг шинжилж онилсон өвчин мөн эсэхийг тогтоохдоо эмнэл зүй, эмгэг судлал, тархвар зүйн шалгуур үзүүлэлтийг харгалзан мэргэжлийн дүгнэлт гаргана. эргэлзээтэй тохиолдолд дээж авч, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулна.

4.2. Хамгаалалттай аж ахуйгаас нийлүүлэх мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолтыг дараах тохиолдолд олгоно.

4.2.1. хамгаалалттай аж ахуйгаас зах зээлд нийлүүлж байгаа, эсвэл хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламж хооронд шилжүүлж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд;

4.2.2. хамгаалалттай аж ахуйн биохамгааллын шаардлагыг хангасан мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд;

4.3. Нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолт олгох эрх бүхий албан тушаалтныг хамгаалалттай аж ахуйн үйлдвэр тус бүрийн биохамгааллын зааварт тодорхой заасан байна.

4.4. Энэ журмын 4.2-г заасан нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолтын загварыг Мал эмнэлгийн ерөнхий газар батална.

4.5. Нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолт нь экспортын мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд олгох олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний дагалдах баримт бичиг болно.

4.6. Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч/нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолтод гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан биохамгааллын шаардлагад нийцсэн эсэхийг нотлох баримтыг бүртгэлжүүлэн хадгалж, шаардлагатай тохиолдолд экспортын гэрчилгээнд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтанд шалгуулахад бэлэн байлгана.

4.7. Хамгаалалттай аж ахуйгаас зах зээлд нийлүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд олгох нийлүүлэгчийн баталгааны маягтад дараах мэдээллийг тусгасан байна:

4.7.1. бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэлийн байгууламжийн нэр, хаяг;

4.7.2. амьд мал, амьтны тоо толгой, мал амьтны гаралтай бүтээгдэхүүний нийт жин, савлагааны тоо, бүтээгдэхүүний тодорхойлолт;

4.7.3. ачааг хүлээж авах газар;

4.7.4. хамгаалалттай аж ахуйн үйлдвэрээс гарсан огноо;

4.7.5. онилсон өвчин бүрээс эрүүл болох нотолгоо.

4.8. Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь биохамгааллын үйл ажиллагааны явцын талаарх мэдээ, тайланг Биохамгааллын нийтлэг зааварт заасан хугацаанд, жилийн эцсийн мэдээ, тайланг дараа жилийн 2 дугаар сарын 01-ний дотор Малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.9. Биохамгааллын үйл ажиллагааны жилийн эцсийн мэдээ, тайланг дараах үзүүлэлтээр гаргана:

4.9.1. хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламжийн тоо;

4.9.2. хамгаалалттай аж ахуйн хорио цээрийн байгууламжид хүлээн авсан, тэжээх бордох байгууламжаар дамжсан малын тоо, тэдгээрийн хөдлөл зүйн мэдээлэл;

4.9.3. хамгаалалттай аж ахуйгаас зах зээлд нийлүүлсэн мал, малын гаралтай бүтээгдэхүүний нэгдсэн мэдээлэл;

4.9.4. гүйцэтгэсэн хөндлөнгийн хяналт шалгалтын тоо;

4.9.5. хяналт шалгалтаар илэрсэн ноцтой, том, жижиг үл тохирол, тэдгээрийг залруулсан арга хэмжээний мэдээлэл;

4.9.6. онилсон өвчний дотоод тандалтын нэгдсэн дүн шинжилгээний мэдээлэл;

4.9.7. хорио цээрийн байгууламжид хэрэгжүүлсэн үзлэг, шинжилгээний дүнгийн нэгдсэн мэдээлэл.

4.10. Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн мал эмнэлгийн лаборатори ажиллуулах тохиолдолд итгэмжлэл авсан байна.

Тав. Хамгаалалттай аж ахуйд тавих төрийн хяналт

5.1. Малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хамгаалалттай аж ахуйн бүртгэлтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын заавар нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх стратеги, хөтөлбөр болон Биохамгааллын нийтлэг заавартай нийцсэн эсэх;

5.1.2. хамгаалалттай аж ахуйд хэрэгжүүлж байгаа биохамгааллын арга хэмжээ нь энэ журмын хавсралтад заасан онилсон өвчний эпидемиологийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

5.1.3. хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа нь тэдний стратеги төлөвлөгөөнд заасан зорилтот зах зээлийн улстай байгуулсан хорио цээрийн нөхцөл, протоколын шаардлагыг хангаж байгаа эсэх; Тайлбар: хэрэв тухайн улстай хорио цээрийн хэлэлцээр, протокол байгуулаагүй бол хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч биохамгааллын зааврын хүрээнд худалдааны түнштэй хэлцэл хийж болно.

5.1.4. хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн байгууламж нэмэгдсэн, хасагдсан, бүртгэл нь цуцлагдсан зэрэг өөрчлөлт орсон тохиолдолд мэдээллийг тухай бүр бүртгэлд шинэчлэн оруулна.

5.2. Малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. зохих шаардлага хангасан, туршлагатай, ур чадвартай эрх бүхий малын эмч хөндлөнгийн хяналтын аудитыг гүйцэтгэх Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийг томилно;

5.2.2. хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөр, мөн тандалт, вакцинжуулалт, шилжилт хөдөлгөөнд тавигдах шаардлагыг тодорхойлно;

5.2.3. хамгаалалттай аж ахуйд оношилгоо, шинжилгээний үйлчилгээ үзүүлэх төрийн өмчит мал эмнэлгийн лабораторийн хуваарилалт, зохицуулалтыг хийх;

5.2.4. хамгаалалттай аж ахуйд хийх хяналт шалгалтын давтамжийг эрсдлийн үнэлгээ, өмнөх хяналт шалгалтын дүнг үндэслэн тодорхойлох.

5.3. Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын явцад илэрсэн үл тохирлыг дараах байдлаар ангилан тодорхойлох:

5.3.1. өвчин нэвтрэх өндөр эрсдэл үүсгэх эсвэл итгэмжлэгдсэн баталгааны найдвартай байдлыг алдагдуулж болох ноцтой үл тохирол;

5.3.2. өвчин нэвтрэх дунд зэргийн эрсдэл үүсгэх, эсвэл итгэмжлэгдсэн баталгааны найдвартай байдлыг алдагдуулж болох том үл тохирол;

5.3.3. өвчин нэвтрэх бага эрсдэл үүсгэх, эсвэл итгэмжлэгдсэн баталгааны найдвартай байдлыг алдагдуулж болох жижиг үл тохирол.

5.4. Онилсон өвчний оношлох шинжилгээний үндэсний стандартыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах үүргийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори хэрэгжүүлнэ.

5.5. Экспортлох мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо дараах баримт бичгийг хавсаргана:

5.5.1. Монгол улсын албан ёсны баталгаажуулалтын тодорхойлолт;

5.5.2. бараа бүтээгдэхүүний нийлүүлэгчийн баталгаа/баталгаажуулалтын тодорхойлолт.

5.6. Хамгаалалттай аж ахуйд үйлчилгээ оношилгоо, шинжилгээний үйлчилгээ үзүүлэх мал эмнэлгийн лаборатори нь дараах шаардлагыг хангасан байна:

5.6.1. тухайн өвчний оношлогоо, шинжилгээ хийх ISO 17025 –аар итгэмжлэл авсан байх;

5.6.2. оношлох үйлчилгээний бие даасан байдлыг хангах зорилгоор оношлох үйлчилгээний үйлчилгээний үнэ нь үйлчилгээний үр дүнгээс хамааралгүй байх.

Зургаа. Хамгаалалттай аж ахуйн бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх

6.1. Ноцтой үл тохирлыг долоо хоногийн дотор залруулаагүй бол Малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамгаалалттай аж ахуйн статусыг түдгэлзүүлнэ. Хэрэв хамгаалалттай аж ахуй 30 хоногийн дотор залруулах арга хэмжээг хангалттай зохион байгуулж чадаагүй бол хамгаалалттай аж ахуйн статусыг цуцална.

6.2. Хамгаалалттай аж ахуйн үйлдвэрлэлийн аль нэг байгууламжид онилсон өвчин илэрч батлагдсан тохиолдолд статусыг нэн даруй цуцална. [Тайлбар: Хамгаалалттай аж ахуйн хорио цээрийн байгууламжид өвчин илэрсэн тохиолдолд хамгаалалттай аж ахуйн статуст нөлөөлөхгүй]

6.3. Хамгаалалттай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь жилийн тайлангаа ирүүлээгүй, экспортын зах зээлд эрсдэл учруулах эрсдэл үүссэний улмаас хамгаалалттай аж ахуйн статусыг түдгэлзүүлсэн, эсхүл

цуцалсан тохиолдолд түүний үйлдвэрлэлийн бүх байгууламжийн бүртгэл нэгэн адил автоматаар түдгэлзүүлсэн, эсвэл цуцалсанд тооцно.

6.4.Хамгаалалттай аж ахуйн статусыг түдгэлзүүлсэн, эсвэл цуцалснаас өмнөх 30 хоногийн дотор олгосон нийлүүлэгчийн баталгаа нь автоматаар хүчингүй болох ба энэ тухай мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн хүлээн авагчид мэдэгдэнэ.

6.5.Энэхүү журмын 6.4-д заасан нийлүүлэгчийн баталгаанд үндэслэн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ нь нэгэн адил хүчингүй болох бөгөөд энэ тухай импортлогч орны эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

6.6.Тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, экспортын зах зээлд учирч болзошгүй аливаа эрсдэлийг арилгасан тохиолдолд хамгаалалттай аж ахуйн статусыг сэргээж болно.

Долоо.Хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

-----o0o-----

ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ТАРХВАР ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Монгол Улсад бүртгэгдсэн төрөл/ омог (сүүлд бүртгэгдсэн огноо)
 - Шүлхийн вирус (FMDV) төрөл О (2022)
 - Шүлхий А төрөл (2016)
 - Шүлхий Asia1 төрөл (2005)
2. Тээгч
 - Өвчлөмтгий мал, амьтан: үхэр, хонь, ямаа, гахай, сарлаг, тэмээ
 - Зэрлэг амьтан: буга, гөрөөс, зэрлэг гахай
3. Монгол Улс дахь тархвар зүйн статус
 - Монгол улсын хэмжээнд эндемик
4. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас Монгол улсын статусыг хүлээн зөвшөөрсөн байдал
 - Тодорхойлоогүй/хамаарахгүй
5. Монгол Улсын хэрэгжүүлж буй тэмцэх арга хэмжээ
 - Вакцинжуулалт
 - Тандалт судалгаа
 - Тархалтын судалгаа, дэгдэлтийг зогсоох вакцинжуулалт
 - Бүсчлэл (одоогоор өвчингүй гэж хүлээн зөвшөөрсөн ямар нэгэн эрүүл бүс байхгүй)
 - Хамгаалалттай аж ахуй (одоогоор өвчингүй гэж хүлээн зөвшөөрсөн ямар нэгэн хамгаалалттай аж ахуй байхгүй)
6. Халдвар дамжих механизм
 - Халдвартай мал амьтантай шууд харьцах
 - Халдвартай мал, амьтны ялгадас, шүүрлээр дамжих:
 - Халдвартай мал амьтан байрлаж байсан орчин
 - Халдвартай малд ашигласан тоног төхөөрөмж
 - Халдвартай мал амьтан тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай мал байсан орчноор дамжин өнгөрсөн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай мал амьтантай харьцахад эсвэл халдвартай мал амьтан бүхий орчинд хэрэглэж байсан гутал, хувцас (хүний хамрын хөндийд 48 цаг тээгдэнэ)
 - Халдвартай мал, амьтнаас гаралтай бүтээгдэхүүнээр бусад малыг тэжээсэн (жишээ нь хог/хүнсний хаягдлаар тэжээх)
 - Агаар дуслын засаар дамжин тархах
7. Худалдааны эрсдэл бүхий бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий амьд мал
 - Өвчлөмтгий малын үр болон хөврөл үр
 - Өвчлөмтгий малын мах, махан бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий малын сүү, сүүн бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий малын арьс, шир, үс, ноос
 - Өвчлөмтгий мал, амьтны хавьтал болсон тэжээл
8. Нууц үе
 - Дээд тал нь 14 хоног
9. Монгол улсын батлагдсан оношлогооны аргачлал, оношлуурын олдоц
 - Вирус илрүүлэх, тодорхойлох:
 - Вирус ялгах шинжилгээ – батлагдсан
 - RT-PCR – батлагдсан
 - Антиген ELISA - батлагдсан
 - Ийлдэс судлалын шинжилгээ
 - Вирус саармагжуулах урвал - батлагдсан
 - Хатуу үет өрсөлдөөнт ЭЛИЗА /Solid Phase Competition ELISA/ - батлагдсан
 - Шингэн үет саатуулагч ЭЛИЗА /Liquid Phase Blocking ELISA/ - батлагдсан
 - Бүтцийн бус уураг илрүүлэх ELISA - батлагдсан
10. Монгол улсад батлагдсан вакцин болон олдоц

- Type A, ARRIAH RUSSIA
- Type O and A, ARRIAH RUSSIA
- Type Asia 1, ARRIAH RUSSIA
- Type O, A and Asia 1, ARRIAH RUSSIA
- Type O inactivated, LANZHOU CHINA
- Импортоор авдаг

11. Вирус идэвхгүйжүүлэх аргын үзүүлэлтүүд

Дулааны аргаар идэвхгүйжүүлэх:

- 70 хэмд 30 минут
- 132 хэмд 1 секунд

Ph-аар идэвхгүйжүүлэх:

- <6
- >9

Химийн аргаар идэвхгүйжүүлэх:

- Натрийн гидроксид (2%), натрийн карбонат (4%), цитритийн хүчил (0.2%), цууны хүчил (2%), гипохлорит натри (3%), калийн пероксимоносульфат/ натри хлорид (1%) болон хлорын диоксид
- Йодофорууд, аммоны нэгдэл, фенол, ялангуяа органик нэгдэл агуулсан.

Үйлдвэрлэлийн процессын үед идэвхгүйжүүлэх:

- Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос, хялгас, арьс, шир, эвэр, туурай зэрэг бүтээгдэхүүний вирус устгах батлагдсан аргачлалыг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын гаргасан кодоос үзнэ үү.

12. Техникийн үзүүлэлтүүдийн лавлагаа:

Дэлхийн шүлхийн лавлагаа лаборатори, улс орнуудын тайлан: Монгол улс ([Mongolia | World Reference Laboratory for Foot-and-Mouth Disease \(wrlfmd.org\)](http://Mongolia | World Reference Laboratory for Foot-and-Mouth Disease (wrlfmd.org)))

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Шүлхийн өвчний техникийн карт ([FOOT AND MOUTH DISEASE \(woah.org\)](http://FOOT AND MOUTH DISEASE (woah.org)))

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Газрын амьтны эрүүл мэндийн код, Бүлэг 8.8 Шүлхий өвчний халдвар (Terrestrial Code Online Access - WOAH - World Organisation for Animal Health)

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, хуурай газрын амьтны эрүүл мэндийн зааварчилгаа, Бүлэг

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн мэдээллийн систем ([WAHIS \(woah.org\)](http://WAHIS (woah.org))):

- Шүлхий, дүн шинжилгээ, өвчлөлийн нөхцөл байдал, Монгол улс
- Шүлхий, дүн шинжилгээ, тандалт, тэмцэх арга хэмжээ, Монгол улс
- Зургаан сар тутмын тайлангууд, Монгол улс

БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНИЙ ТАРХВАР ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Монгол улсад бүртгэгдсэн төрөл/омог (Бүртгэгдсэн сүүлийн огноо)
Бог малын мялзангийн вирус (PPRV), мөн бог малын морбилливирус хэмээн нэрлэдэг (SRMV) (2022)
2. Тээгч
Өвчлөмтгий мал, амьтан: хонь, ямаа, сарлаг
Зэрлэг амьтан: буга, гөрөөс
3. Монгол улсын тархвар зүйн байдал
Тохиолдлын дэгдэлт хэлбэрээр гардаг
4. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас Монгол улсын статусыг хүлээн зөвшөөрсөн байдал
Тодорхойлоогүй/хамаарахгүй
5. Монгол улсын хэрэгжүүлж буй тэмцэх арга хэмжээ
Вакцинжуулалт
Тандан судалгаа
Хамгаалалттай аж ахуй (Одоогоор өвчнөөс эрүүл болохыг хүлээн зөвшөөрсөн хамгаалалттай аж ахуй байхгүй)
6. Халдвар дамжих механизм
Халдвартай мал амьтантай шууд харьцах
Халдвартай мал, амьтны ялгас, шүүрлээр дамжих:
 - Халдвартай мал амьтан байрлаж байсан орчин
 - Халдвартай малд ашигласан тоног төхөөрөмж
 - Халдвартай мал амьтан тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай мал байсан орчноор дамжин өнгөрсөн тээврийн хэрэгсэл
 - Халдвартай мал амьтантай харьцахад эсвэл халдвартай мал амьтан бүхий орчинд хэрэглэж байсан гутал, хувцас
7. Худалдааны эрсдэл бүхий бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий амьд мал
 - Өвчлөмтгий малын үр болон хөврөл үр
 - Өвчлөмтгий малын мах, махан бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий малын сүү, сүүн бүтээгдэхүүн
 - Өвчлөмтгий малын арьс, шир, үс, ноос
 - Өвчлөмтгий мал, амьтны хавьтал болсон тэжээл
8. Нууц үе
Дээд тал нь 21 хоног
9. Монгол улсын батлагдсан оношилгооны аргачлал, олдоц
Вирус тодорхойлох:
 - Вирус ялгах шинжилгээ - батлагдсан
 - RT-PCR - батлагдсан
 - Дархлаа саатуулагч ЭЛИЗА /immunocapture ELISA/ - батлагдсан
 - Түргэн тест /Penside Lateral Flow Device (LFD)/ - батлагдсанИйлдэс судлалын шинжилгээ
 - Вирус саармагжуулах урвал - батлагдсан
 - Өрсөлдөөнт ЭЛИЗА /Competitive ELISA/ - батлагдсан
 - Agar Gel Immunodiffusion (AGID) - батлагдаагүй
10. Монгол улсын бүртгэсэн вакцин, олдоц
 - Pestevac Nigeria 75/1 (PPR), JOVAC JORDAN импортоор авдаг
11. Вирус идэвхгүйжүүлэх аргын үзүүлэлтүүд
Дулааны үйлчлэлээр идэвхгүйжүүлэх:
 - 70 хэмд 30 минутPh-ын тохиргоогоор идэвхгүйжүүлэх:
 - <4
 - >11Химийн аргаар идэвхгүйжүүлэх:

- Спирт, эфир болон түгээмэл хэрэглэдэг угаалгын бодис болон ихэнх ариутгалын бодис, үүнд фенол болон натрийн гидроксид (2%)

Үйлдвэрлэлийн процессын үед идэвхгүйжүүлэх:

- Мах, махан бүтээгдэхүүн, өлөн гэдэс, ноос, хялгас, арьс, шир, эвэр, туурай зэрэг бүтээгдэхүүний вирус устгах батлагдсан аргачлалыг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын гаргасан кодоос үзнэ үү.

12. Техникийн үзүүлэлтүүдийн лавлагаа:

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Мязан өвчний техникийн карт ([WOAH PPR Technical Disease Card](#))

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага, Хуурай газрын мал, амьтны эрүүл мэндийн код (Terrestrial Code), Бүлэг 14.7 Бог малын мязан өвчний вирусийн халдвар ([Terrestrial Code Online Access - WOAH - World Organisation for Animal Health](#))

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Хуурай газрын амьтны эрүүл мэндийн зааварчилгаа (Terrestrial Manual), Бүлэг 3.8.9. Бог малын мязан (Бог малын мязангийн морбилливирусийн халдвар) ([WOAH Terrestrial Manual: Chapter 3.8.9 PPR](#))

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн мэдээллийн систем ([WAHIS \(woah.org\)](#)):

- Зургаан сар тутмын тайлан, Монгол улс

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO), EMPRES-i ([Empres-i \(fao.org\)](#))

Бог малын мязан өвчнийг олон улсад устгах хөтөлбөр 2 болон 3 (Peste des petits ruminants Global Eradication Programme II & III): Үйл ажиллагааны төлөвлөгөөний тойм ([PPR Global Eradication Programme I & III](#))